

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН НЭВТРҮҮЛЭХ, БҮРТГЭХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын хилээр нэвтэрч буй худалдан авсан болон түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх болон гэрчилгээ олгох /цаашид “хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх, гэрчилгээ олгох” гэх/-той холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх, гэрчилгээ олгох үйл ажиллагаанд үнэн зөв, шуурхай, ил тод, хууль тогтоомжийг сахин мөрдөх зарчмыг баримтална.

1.3. Энэхүү журмыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, суурь бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, өмчлөгч, түрээслэгч, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.4. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх, гэрчилгээ олгох ажилтан, иргэн, хуулийн этгээд нь Олон улсын төмөр замын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, журам, стандарт, Монгол Улсын хил, гаалийн байгууллагын холбогдох эрх зүйн акт, хилийн төмөр замын өртөөний технологийн горим, энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.5. Энэхүү журамд хэрэглэх нэр томьёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, журам, үндэсний стандартад заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

1.6. Монгол Улсын хилийн төмөр замын өртөө нь хөдлөх бүрэлдэхүүнд техникийн болон хил, гаалийн үзлэг, шалгалт хийх нөхцөлөөр бүрэн хангагдсан байна.

1.7. Монгол Улсын хилээр нэвтэрсэн илчит тэргийг илгээхдээ тухайн суурь бүтэц эзэмшигч байгууллагын зүтгүүрийн инженер, техникийн ажилтан ТУ-25 актыг бүрдүүлснийг үндэслэн хөдөлгөөнд оролцуулна.

1.8. Тухайн хөдлөх бүрэлдэхүүнд Монгол Улсын хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, журам, стандартын дагуу дугаар, гэрчилгээ авах, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх, засвар үйлчилгээнд тогтсон хугацаанд оруулах нь хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн үүрэг байна.

1.9. Онцгой байдлын үед шуурхай нэвтрүүлэх шаардлагатай /аврах, сэргээн босгох, гал унтраах галт тэрэг, бүтээн байгуулалттай холбоотой зайлшгүй шаардлагаар нойтон түрээсээр ашиглах зам, засварын машин механизм г.м/ хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд энэ журам хамаарахгүй.

Хоёр. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн
эзэмшигч, түрээслэгч болон хөдлөх бүрэлдэхүүнд
тавигдах техникийн шаардлага

2.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. хөдлөх бүрэлдэхүүн, түүний баримт бичиг нь Олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хууль, стандартад заасан шаардлагыг хангасан байх;

2.1.2. хөдлөх бүрэлдэхүүн нь техникийн байдлыг тодорхойлох техникийн баримт бичиг /гэрчилгээ/-тэй байх;

2.1.3. хөдлөх бүрэлдэхүүн нь шинэ эсхүл ашиглалтын хугацаа нь Монгол Улсын үндэсний стандартаар тогтоосон хугацааны 1/3 /гуравны нэгээс/ хэтрэхгүй байна. Уг хугацаанаас хэтрэхгүй ашигласан хөдлөх бүрэлдэхүүнийг оруулж ирэхдээ эрх бүхий байгууллагаар засвар, оношилгоо хийлгэсэн байх, мөн техникийн бүрэн бүтэн байдал, хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангаж байгааг нотолсон баримт бичгийг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага нь бүрдүүлсэн байна.

2.1.4. Худалдан авч байгаа болон түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүний хатуу дугаартай цутгамал эд ангийн насжилт нь вагоны ашиглагдсан хугацаанаас ихгүй байна.

2.1.5. Монгол Улсын хилээр нэвтрүүлэх хөдлөх бүрэлдэхүүн нь тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад үйлдвэрлэгдсэн байна.

2.2. Монгол Улсын хилээр шинээр оруулан ирж, төмөр замын тээвэрт ашиглах хөдлөх бүрэлдэхүүний техникийн нөхцөл, шаардлага, дугаарлалт, тэмдэг тэмдэглэгээ нь энэхүү журамд заасан баримт бичгийн шаардлагыг хангасан байна. Мөн тухайн улсын нутаг дэвсгэр дээр худалдан авах болон түрээслэх хөдлөх бүрэлдэхүүнд хийсэн техникийн үзлэг, акт дүгнэлтийг ирүүлсэн байна.

2.4. Хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд Гаалийн тухай хуульд заасны дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

2.5. Монгол Улсын төмөр замын тээвэрт түрээсээр ашиглагдах хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн хугацаа нь дунд засварын хугацаанаас хэтрэхгүй байна.

2.7 Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгч байгууллага нь хөдлөх бүрэлдэхүүнд засвар үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагыг сонгон үйлчлүүлнэ. Засвар үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хөдлөх бүрэлдэхүүнд засвар, үйлчилгээ хийлгэсэн тохиолдолд тухайн хөдлөх бүрэлдэхүүнийг засварыг төмөр замын байгууллагууд хүлээн зөвшөөрч тээвэрлэлтэд явуулна.

Гурав. Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх,
бүртгэл хөтлөх, гэрчилгээ олгох

3.1. Монгол Улсад ашиглахаар худалдан авч буй хөдлөх бүрэлдэхүүнийг захиалан үйлдвэрлүүлэх, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхээс өмнө үйлдвэрлэгчийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл, хийц, зураг төсөл, техникийн баримт бичгийг Төрийн захиргааны байгууллагатай урьдчилж зөвшилцөн техникийн нөхцөлийн дүгнэлт авна.

3.2. Иргэн, хуулийн этгээд нь хөдлөх бүрэлдэхүүнтэй холбоотой дараах мэдээллийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж, зөвшөөрөл авсны дараа Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ. Үүнд:

3.1.1. хөдлөх бүрэлдэхүүн шинээр худалдан авах, түрээслэх иргэн, хуулийн этгээдийн дүгнэлт гаргуулах албан хүсэлт;

3.1.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;

3.1.3. хөдлөх бүрэлдэхүүний төрөл, хийц, бүдүүвч, гэрэл зураг, үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт, ашиглах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичиг;

3.1.4. хөдлөх бүрэлдэхүүнд засвар, оношилгоо үйлчилгээ хийгдсэн байдлыг тодорхойлсон баримт бичиг, техникийн байдлын талаарх дүгнэлт, тухайн улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөл бүхий гэрчилгээний хуулбар;

3.1.5. худалдан авах болон түрээслэхтэй холбоотой гэрээний хуулбар, түүний баталгаат орчуулга;

3.1.6. хөдлөх бүрэлдэхүүн худалдан авах, түрээслэх иргэн, хуулийн этгээд нь тухайн хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хариуцах мэргэжлийн инженертэй байна.

3.1.7. хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, түрээслэх иргэн, хуулийн этгээд нь хилээр нэвтрэх нийт хөдлөх бүрэлдэхүүнийг томьёолсон уртаар бүрэн багтах хэмжээний өөрийн эзэмшлийн салбар замтай байх эсхүл салбар зам эзэмшигч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх;

3.3. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичиг, холбогдох мэдээллийг үндэслэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж, хөдлөх бүрэлдэхүүний техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, журам, үндэсний стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах ажлыг Монгол Улсын хилийн боомт болон хилийн өртөө эсвэл хүсэлт гаргагчийн өөрийн эзэмшлийн болон гэрээт салбар замд хийж гүйцэтгэнэ.

3.4. Энэхүү журмын 3.3-т заасан дүгнэлтийг хүсэлт гаргагчийн өөрийн эзэмшлийн болон гэрээт салбар замд хийж гүйцэтгэх тохиолдолд төмөр замын тээврийн

байгууллага нь Олон Улсын вагон эдэлгээний дүрэмд заасны дагуу бүрэн үзлэгийг хийж Монгол Улсын хилээр нэвтрүүлэн тухайн салбар замд байршуулна.

3.5. Журмын 3.3-т заасан дүгнэлт нь хөдлөх бүрэлдэхүүнийг Монгол Улсын төмөр замын тээвэрт ашиглах, эс ашиглах үндэслэл болно.

3.6. Төрийн захиргааны байгууллага нь жил бүрийн эхэнд худалдан авах, түрээслэх хөдлөх бүрэлдэхүүний төрөл, тоог хөдлөх бүрэлдэхүүний эрэлт хэрэгцээ, суурь бүтцүүдийн багтаамж, галт тэрэг урсгалын тооцоололд үндэслэн суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боломжит хөдлөх бүрэлдэхүүний тоог тодорхойлно.

3.7. Ажлын хэсгийн ажиллах зардлыг хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, түрээслэх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд хариуцна.

3.8. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дүгнэлт, шийдвэрийг үндэслэн худалдан авсан хөдлөх бүрэлдэхүүнд үндэсний стандартын дагуу дугаар, өмчлөгчийн код, түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүнд түрээслэгчийн код шинээр олгож, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

3.9. Энэхүү журмын 3.1-т заасан хөдлөх бүрэлдэхүүнд урьдчилан дугаар авахад худалдах, худалдан авах гэрээ, сорилт туршилтыг бүрэн хийж баталгаажуулсан баримт бичиг, үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээ, вагон үйлдвэрлэх үеийн фото зураг, акт болон бусад баримт бичгийг үндэслэн 6 сар хүртэлх хугацаанд олгож болно.

3.10. Түрээсийн хөдлөх бүрэлдэхүүний гэрээний хугацаа дуусгавар болох, хугацаат засварт орохоор хилээр гарах, хилээр буцаж орж ирэх, хөдлөх бүрэлдэхүүнийг давхар түрээслэх, түрээсийн хугацаа дуусаж хилээр гарах тохиолдолд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон төмөр замын тээврийн байгууллагад заавал мэдэгдэнэ.

3.11. Түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүн нь үйлдвэрийн газартаа хугацаат засварт ороод ирэх, хугацаат засварт орохоор хил гарсан хөдлөх бүрэлдэхүүний оронд нөхөн ирж байгаа үед энэхүү журмын 3.1, 3.2 дахь заалтыг мөрдлөг болгоно.

3.12. Энэхүү журмын 2.5 дахь заалтын дагуу түрээсээр ашиглах хөдлөх бүрэлдэхүүн нь хугацаат засварт орж Монгол Улсын хилээр нэвтрэхэд энэхүү журмын 3.2, 3.3 дахь заалтыг мөрдлөг болгоно.

3.13. Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын нормт хугацаа дууссан, осол сүйрэлд орж ашиглах боломжгүй тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт гарсан, эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, хөдлөх бүрэлдэхүүнд олгосон дугаарыг дахин ашиглахгүй.

3.14. Төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 3.1-т заасан хөдлөх бүрэлдэхүүний үйлдвэрлэлт, угсралтын үе шатны ажлуудад хүсэлт гаргагчтай зөвшилцсөний үндсэн дээр явцын үзлэг, шалгалтыг хийж болно.

Дөрөв. Монгол улсын хилээр нэвтэрч буй
хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэх

4.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхдээ төмөр замын тээврийн байгууллага нь энэхүү журмын 1.4, 3.1, 3.2, 3.3-т заасан баримт бичгийн шаардлагыг ханган бүрдүүлж хөтөлнө.

4.2. Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх ажиллагааг тухайн төмөр замын тээврийн байгууллага, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч харилцан зөвшилцөн зохион байгуулж Монгол Улсын хилийн боомт болон хилийн өртөө эсвэл хүсэлт гаргагчийн өөрийн эзэмшлийн болон гэрээт салбар замд хийж гүйцэтгэнэ.

Тав. Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүнд
гэрчилгээ олгох

5.1. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектын гэрчилгээг Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох үндэсний стандартад нийцүүлэн гэрчилгээжүүлэх ажлыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

5.2 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектын гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг, гэрчилгээг сунгахад тавигдах шаардлага, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох болон мэдээллийн сан бүрдүүлэлт, хөтлөлт, хадгалалт, ашиглалт, хяналт хариуцлагыг “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам”-аар зохицуулна.

5.3. Төмөр замын тээврийн байгууллага нь Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хөдлөх бүрэлдэхүүний объектын гэрчилгээтэй иргэн, хуулийн этгээдтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд гэрээ байгуулж хамтран ажиллана.

5.4. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектын гэрчилгээг дараах байдлаар ангилна:

- бүх төрлийн зүтгүүр;
- бүх төрлийн ачааны вагон;
- бүх төрлийн зорчигчийн вагон;
- сэргээн босгох, гал унтраах галт тэрэг;
- зам засвар, арчлалт, оношилгоо, хэмжилт хийх бүх төрлийн машин механизм;
- төмөр замаар явагч тусгай зориулалтын техник хэрэгсэл.

5.5 Шинээр худалдан авсан хөдлөх бүрэлдэхүүнд "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектын гэрчилгээ"-г үйлдвэрлэлснээс хойш их засварт орох хүртэлх хугацаагаар олгоно.

5.6 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектын гэрчилгээг үйлдвэрлэснээс хойш их засварт орж, ашиглах талаарх дүгнэлт, шийдвэрийг үндэслэн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын нормт хугацаа дуусах хүртэлх хугацаагаар сунгана.

5.7 Монгол Улсын хилээр шинээр оруулж ирэх хөдлөх бүрэлдэхүүн урьд нь тээвэрт ашиглагдаж байсан бол эрх бүхий байгууллагаар засвар, оношилгоо хийлгэсэн байх, мөн техникийн бүрэн бүтэн байдал, хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангаж байгааг нотолсон баримт бичиг, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн гэрчилгээ олгоно.

5.8 Объектын гэрчилгээний хүчинтэй хугацаанд өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч солигдсон, осол, сүйрлийн дараа ашиглах талаар дүгнэлт гарсан, дахин ашиглах хугацааг тогтоосон, гэрчилгээг бохирдуулсан, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд албан хүсэлт, гэрчилгээ болон холбогдох материалыг ирүүлж гэрчилгээг нөхөн олгоно.

5.9 Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын нормт хугацаа дууссан, осол сүйрэлд орж ашиглах боломжгүй дүгнэлт гарсан, эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд нэг сарын дотор Төрийн захиргааны байгууллагад хүсэлт өгч мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээг хүчингүй болгоно.

5.10 Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөдлөх бүрэлдэхүүнийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан тохиолдолд дугаарыг өөрчлөх, эзэмшигч солих бүртгэл хийгдэхгүй.

5.11 Гэрчилгээ шинээр авах тухай хүсэлт гаргахдаа төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартын шаардлагыг үндэслэн дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

5.12 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектын гэрчилгээ авахад тавигдах шаардлага:

- зохих журмын дагуу гаргасан иргэн, хуулийн этгээдийн албан хүсэлт;
- улсын бүртгэлийн гэрчилгээ /иргэний үнэмлэх/-ний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- гэрчилгээжүүлэх объектын танилцуулга;
- тухайн объектын гарал үүсэл, тохирлын эсхүл чанарын гэрчилгээ, паспорт, засвар өөрчлөлтийн бүртгэл, ашиглалтын заавар, техникийн зураг, схем;
- худалдах, худалдан авах гэрээ, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ бусад шаардлагатай баримт бичиг;
- гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг
- Улсын тэмдэгтийн хураамж, хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээний үнэ, үйлчилгээний хөлс төлсөн баримт;
- Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын заавар, аргачлал

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага болон суурь бүтэц эзэмшигч нар тус тусын чиг үүргийн хүрээнд энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.

6.2. Төмөр замын тээврийн байгууллага болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”, “Хөдлөх бүрэлдэхүүн ашиглах журам”-д заасны дагуу ашиглагдаж байгаа болон нөөцөд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын тайлан, судалгааг хагас, бүтэн жилээр гарган, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж, тус байгууллага нь тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулан, хяналт тавина.

6.3. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн байгууллага нь энэ журамд зааснаас өөр үйл ажиллагаа хэрэгжүүлэх, бусад баримт бичгийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.

6.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

Зам, тээврийн сайдын 20 ... оны ...
дүгээр сарын ... ны өдрийн ... дугаар
тушаалаар баталсан Монгол Улсын

хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх,
бүртгэх, гэрчилгээ олгох журмын
нэгдүгээр хавсралт

Хүйтэн байдалд зөөвөрлөхөд зориулсан зүтгүүр /кран/, моторт-вагон
галт тэрэгний /секц/ техникийн байдлыг шалгах
АКТ /Маягт ТУ-25/

20_ оны__ сарын__ өдөр бид, дор гарын үсэг зурсан бүрэлдэхүүнээр

(зүтгүүрийн (кран), моторт-вагон, секц)

_____ серийн № _____ дугаартай зүтгүүрийн техникийн байдлыг шалгаж энэхүү
актыг тогтоов:

а) дэлний хэмжээ хамгийн бага _____

хос дугуй баруун талдаа _____ мм, зүүн талдаа _____ мм;

б) бандаж нь хамгийн их хурц ирмэгтэй _____

хос дугуй _____ талдаа _____ мм:

в) хос дугуйн хөндлөн гүйлт _____ ;
(хэвийн хэмжээнд)

г) бүх хос дугуйн дэлэнд _____
(ямар нэгэн)

(хурц ирмэг)

д) явах ангийн хөдөлгөөнт механизмуудыг тослох төхөөрөмжүүдийг шалгасан

(гэмтэлгүй байдалтай байх)

Үрэлдэгч эд ангиудад тосолгооны хангамж _____ ;
(хэвийн)

е) тоормос, тэр тусмаа гар тоормос _____ ;
(гэмтэлгүй)

ж) хамгаалах төхөөрөмжүүд _____ ;
(гэмтэлгүй)

з) Илчит тэрэгний засварын дүрэмд тусгагдсан гүйлтийн болон дэмжих
тэргэнцрийн хяналтын хэмжээсүүдийн байдал _____ ;

и) Дагалдан хүргэгчид зориулсан зуух болон ороор тоногдсон (зүтгүүрийн (моторт вагон) үйлдвэрлэгчийн зургийн шаадлага эсвэл ПКБ, ЦТ шаардлагын дагуу, хос татлагын нэгдсэн кранд чөлөөтэй хүрэх боломжтой);

к) энэ серийн шинэ зүтгүүрийг тээвэрлэх тэр тусмаа хүйтэн байдалд аюулгүй тээвэрлэх тухай зүтгүүрийн үйлдвэрийн техникийн нөхцөлийн бүх шаардлагыг

_____ ;
(бүрэн гүйцэтгэх)

л) краны сум ба түүний тулгуур

_____ ;
(тээвэрлэлтийн байдалд бэхэлсэн)

1. _____ ;
(зүтгүүр, моторт вагон, кран, секцийн нэр)

2. Хүйтэн байдалд зүтгүүр (кран), моторт вагон (секц) тээвэрлэхэд дагалдан хүргэгчид энэхүү актын хувийг хүлээлгэн өгсөн болно.

3. Зүтгүүрийн дагалдан хүргэгч

_____ ;
(овог нэрийг заах)

Дагалдан хүргэгчид хүйтэн байдалд зүтгүүр (кран), моторт вагон (секц) тээвэрлэх заавар болон цахилгаанжуулсан төмөр замын хэсэгт ажиллах ажилтан аюулгүй ажиллагааны зааварчилгааны мэдлэгийг эзэмшсэн болно.

Зүтгүүрийн улсын байцаагч эсвэл тээврийн хяналтын
албаны чиглэл хариуцсан байцаагч / _____ /

Депогийн дарга / _____ /

Автотоормосын зааварлагч машинч / _____ /

ЦТ МПС зааварлагч хүлээн авагч эсвэл

Зүтгүүрийн хүлээн авагч / _____ /

Зүтгүүрийн\кран/, моторт вагоны дагалдан хүргэгч
/ _____ /

/ _____ /

/ _____ /

/ _____ /

Зам, тээврийн сайдын 20 ... оны ... дүгээр
сарын ... ны өдрийн ... дугаар тушаалаар

баталсан Монгол Улсын хилээр хөдлөх
бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх,
гэрчилгээ олгох журмын **хоёрдугаар**
хавсралт

Хос дугуйн хэмжилт

№	Секц	Хос дугуйн №		Хурц ирмэг		Дэл		Бандаажны зузаан	
1									
2									
3									
...									

МОП

Хос дугуй	Секц	1	2	3	4	5	6
Коплектор тал							
Араатай тал							

Авто угсраа, цас хамагч

Нэр	Дугаар	Өндөр, мм	Тайлбар
Урд автоугсраа			
Арын автоугсраа			
Цас хамагч			

Цехийн мастер / _____ /..... /

Хэмжигч техникч / _____ /..... /

—oOo—

Зам, тээврийн сайдын 20 ... оны ... дүгээр
сарын ... ны өдрийн ... дугаар тушаалаар

баталсан Монгол Улсын хилээр хөдлөх
бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх,
гэрчилгээ олгох журмын **гуравдугаар**
хавсралт

ШАЛГАСАН ТЕХНИКИЙН

АКТ №

20..... оны сарын өдөр

.....-ын худалдан авсан/түрээсэлсэн
(худалдан авах, түрээслэх иргэн, хуулийн этгээдийн нэр)

..... ширхэг

(тоо хэмжээ) (вагоны төрөл)

..... тус тус үндэслэн Зам, тээврийн
хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр
замын газрын 20..... оны дүгээр сарын-ны өдрийн “Ажлын хэсэг томилох
тухай” дугаар тушаалын дагуу Монгол Улсын төмөр замын тээвэрлэлтэд
шинээр нэмэгдэж буй худалдан авсан/түрээсийн ширхэг төрлийн
..... вагон нь техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад
нийцэж байгаа эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсэг

..... (үзлэг хийсэн газрыг тодорхой бичих) техникийн үзлэг хийж, анхны
акт тогтоолоо.

Ажлын хэсгийг

.....ахлаж, нарийн бичгийн
даргаар

.....,
гишүүдэд

..... нарын бүрэлдэхүүнтэй ажилласан. Үзлэгээр дараах нөхцөл байдал илэрлээ. Үүнд:

№	Вагон дугаар	Вагоны төрөл	Модель	Үйлдвэрлэсэн он	Дунд засварын хугацаа	Их засварын хугацаа	Тээвэрлэлтэнд тэнцэх/эсэх	Хөдөлгөөнд тэнцэх/эсэх	Тайлбар

Дүгнэлт:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Ажлын хэсгийн ахлагч:

..... / /

(албан тушаал) (гарын үсэг)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

..... / /

(албан тушаал) (гарын үсэг)

Ажлын хэсгийн гишүүд:

1. / /

(албан тушаал) (гарын үсэг)

2. / /

(албан тушаал) (гарын үсэг)

3. ...

Эзэмшигч / түрээслэгч:

4. / /

(албан тушаал) (гарын үсэг)

Зам, тээврийн сайдын 20 ... оны ... дүгээр сарын ... ны өдрийн ... дугаар тушаалаар баталсан Монгол Улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэх, гэрчилгээ олгох журмын **дөрөвдүгээр хавсралт**

ТӨМӨР ЗАМЫН ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ОБЪЕКТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЭХ ЗАГВАР, ТҮҮНД ТАВИГДАХ МЭДЭЭЛЭЛ

1. Гэрчилгээний нүүрэн тал, түүний агуулга:

1.1. гэрчилгээ нь нууцлал бүхий үнэт цаас байна;

1.2. гэрчилгээ нь А4 буюу 21х29.7 см-ийн хэмжээтэй байх ба 157 граммтай цаасыг ашиглана;

1.3. гэрчилгээний дээд хүрээнээс 5.5 мм-ийн зайд төв хэсэгт нь 17х35 мм хэмжээтэй соёмбыг байрлуулна. Соёмбо нь үндэсний стандартад заасан шаардлагыг хангасан байна;

1.4. гэрчилгээний дээд хэсэгт байрлах соёмбын доод талд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийг том үсгээр бичсэн байна;

1.5. объектын гэрчилгээнд бичигдэх өгөгдлүүд нь монгол хэл дээр бичигдэж, англи хэл дээр орчуулагдан бичигдсэн байна;

1.6. гэрчилгээнд бичигдсэн Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийн доод талд “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектийн гэрчилгээ” гэсэн гарчиг байх ба түүний баруун доод талд гэрчилгээний дугаарыг бичнэ;

1.7. гэрчилгээний дугаар нь олгогдсон он, өмчлөгч эзэмшигчийн код, бүртгэлийн дугаарын тооноос тус тус бүрдэнэ;

1.8. төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектын нэр төрөл бүр дээр дугаарлалт хийгдэнэ;

1.9. гэрчилгээнд сунгалт хийх үед гэрчилгээний арын “Сунгалт, өөрчлөлтийн бүртгэл” хэсэгт тэмдэглэл хийж, гарын үсэг, тамга дарж баталгаажуулах эсхүл шинээр олгоно;

1.10. гэрчилгээний дугаарын зүүн доод талд тухайн гэрчилгээний төрөлд оногдох кодыг бичнэ (хүснэгт 1-д заагдсан);

1.11. гэрчилгээний дунд хэсэгт гэрчилгээ эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн нэр, албан ёсны хаяг /улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх/, гэрчилгээ олгогдож байгаа объектын нэр төрөл, зориулалтыг тодорхойлж бичнэ;

1.12. гэрчилгээний доод хэсэгт олгосон он, сар, өдөр, дуусгавар болох он, сар, өдрийг тус тус бичнэ.

2. Гэрчилгээний ар тал, түүний агуулга:

2.1. объектын болон үйл ажиллагааны гэрчилгээний ар талд 2 удаагийн сунгалт, өөрчлөлтийн бүртгэлийн хэсгийг оруулсан байна.

2.2. “Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгож буй энэхүү объектын гэрчилгээ нь тухайн объект нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж байгааг тодорхойлсон баримт бичиг болно” гэсэн санамж гэрчилгээний ард бичигдсэн байна.

2.3. Объектын гэрчилгээний ард тухайн объект (хөдлөх бүрэлдэхүүн)-д хамаарах Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй Монгол Улсын Үндэсний стандарт, олон улсын болон бүс нутгийн техникийн зохицуулалтын баримт бичиг, түүнчлэн техникийн нөхцлийг тусгана.

2.4. Объектын гэрчилгээжүүлэхэд тавигдах шаардлага, техникийн нөхцөлийг 2-7 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Нэгдүгээр хүснэгт

Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний объектийн гэрчилгээ

№	Объектийн код	Хөдлөх бүрэлдэхүүний төрөл
1	О-4 ХБ-1	Зүтгүүр
2	О-5 ХБ-2	Зорчигчийн вагон
3	О-6 ХБ-3	Ачааны вагон
4	О-7 ХБ-4	Зам засвар, арчлалт, оношилгоо, хэмжилт хийх бүх төрлийн вагон, машин механизм
5	О-8 ХБ-5	Сэргээн босгох, гал унтраах галт тэрэг
6	ХБ - 6	Төмөр замаар явагч тусгай зориулалтын техник хэрэгсэл.

Хоёрдугаар хүснэгт

Бүх төрлийн зүтгүүрийн техникийн нөхцөл

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Эзэмшигчийн нэр	
2	Төрөл, зориулалт	
3	Зүтгүүрийн бүртгэлийн дугаар	
4	Голын тоо	
5	Зүтгүүрийн хувийн жин, т	
6	Нэг гол дээрх даралт, т	
7	Түлшний савны багтаамж, л	
8	Тосны савны багтаамж, л	
9	Элсний савны багтаамж, л	
10	Усны савны багтаамж, л	
11	Дизель генераторын дугаар, чадал, кВт	
12	Татах генераторын дугаар, чадал, кВт	
13	Статер генераторын дугаар, чадал, кВт	
14	Сэрээгчийн дугаар	
15	Дамжлагын төрөл	
16	Тэргэнцрийн дугаар: 1 дүгээр, 2 дугаар	
17	Хос дугуйн дугаар	
18	Их засварт орсон огноо	
19	Урсгал засварт орсон огноо	
20	Үйлдвэрлэгдсэн он, улс	
21	Бусад	

Гуравдугаар хүснэгт**Бүх төрлийн зорчигчийн вагоны техникийн нөхцөл**

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Эзэмшигчийн нэр	
2	Төрөл, зориулалт	
3	Вагоны бүртгэлийн дугаар	
4	Овор	
5	Даац/(хувийн жин),т	
6	Зорчигчийн суудлын тоо	
7	Тэвшний урт, өргөн, өндөр, ммхммхмм	
8	Голын тоо	
9	Хийцийн хурд, км/цаг	
10	Тэргэнцрийн төрөл	
11	Ниших татах байгууламжийн төрөл	
12	Хос дугуйн төрөл	
13	Ашиглалтын байдал, ашигласан хугацаа	
14	Автотоормосын төрөл	
15	Авто угсрааны төрөл, тоо/ш	
16	Дотоод тоноглолын ангилал, төрөл	
17	Үйлдвэрлэгдсэн он, улс	
18	Бусад	

Дөрөвдүгээр хүснэгт**Бүх төрлийн ачааны вагоны техникийн нөхцөл**

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Эзэмшигчийн нэр	
2	Төрөл, зориулалт	
3	Вагоны бүртгэлийн дугаар	
4	Овор	
5	Даац/хувийн жин,т	
6	Эзлэхүүн, м ³	
7	Голын тоо	
8	Хийцийн хурд, км/цаг	
9	Тэргэнцрийн төрөл, дугаар	
10	Ниших татах байгууламжийн төрөл	
11	Хос дугуйн төрөл	
12	Ашиглалтын байдал, ашигласан хугацаа	
13	Автотоормосын төрөл	
14	Үйлдвэрлэгдсэн он, улс	
15	Бусад	

Тавдугаар хүснэгт

Бүх төрлийн замын машин механизмын техникийн нөхцөл

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Эзэмшигчийн нэр	
2	Төрөл, зориулалт	
3	Замын машин механизмын бүртгэлийн дугаар	
4	Голын тоо	
5	Замын машин механизмын хувийн жин, т	
6	Нэг гол дээрх даралт, т	
7	Түлшний савны багтаамж, л	
8	Тосны савны багтаамж, л	
9	Элсний савны багтаамж, л	
10	Усны савны багтаамж, л	
11	Дизель генераторын дугаар, чадал, кВт	
12	Татах генераторын дугаар, чадал, кВт	
13	Статер генераторын дугаар, чадал, кВт	
14	Сэрээгчийн дугаар	
15	Дамжлагын төрөл	
16	Тэргэнцрийн дугаар: 1 дүгээр, 2 дугаар	
17	Хос дугуйн дугаар	
18	Их засварт орсон огноо	
19	Урсгал засварт орсон огноо	
20	Үйлдвэрлэгдсэн он, улс	
21	Бусад	

Зургаадугаар хүснэгт

Сэргээн босгох, гал унтраах галт тэрэг

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Эзэмшигчийн нэр	
2	Төрөл, зориулалт	
3	Сэргээн босгох, гал унтраах галт тэрэгний бүртгэлийн дугаар	
4	Хөдлөх бүрэлдэхүүний тоо	
5	Голын тоо	
6	Түлшний савны багтаамж, л	
7	Тосны савны багтаамж, л	
8	Элсний савны багтаамж, л	
9	Усны савны багтаамж, л	
10	Краны даац, тн	
11	Дизель генераторын дугаар, чадал, кВт	
12	Татах генераторын дугаар, чадал, кВт	

13	Статер генераторын дугаар, чадал, кВт	
14	Засварт орсон мэдээлэл	
15	Бусад	

Долоодугаар хүснэгт

Төмөр замаар явагч тусгай зориулалтын техник хэрэгслийн техникийн нөхцөл

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Эзэмшигчийн нэр	
2	Төрөл, зориулалт	
3	бүртгэлийн дугаар	
4	Голын тоо	
5	Хувийн жин, т	
6	Нэг гол дээрх даралт, т	
7	Түлшний савны багтаамж, л	
8	Тосны савны багтаамж, л	
9	Элсний савны багтаамж, л	
10	Усны савны багтаамж, л	
11	Генераторын дугаар, чадал, кВт	
12	Даац, чирэх чадал тн	
13	Тэргэнцрийн дугаар	
14	Хос дугуйн дугаар	
15	Засварт орсон мэдээлэл	
16	Бусад	

----o0o----